

БАТЛАВ.
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Э.Балжинням* Э.БАЛЖИННЯМ
2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН АЖИЛТАН АЛБАН ХААГЧДЫН ДУНД
ЗОХИОН БАЙГУУЛАХ "ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙ, САХИЛГА
ХАРИУЦЛАГА СЭДЭВТ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН УДИРДАМЖ

2022.11.01

Улиастай

Нэг. Үндэслэл

Аймгийн Засаг даргын 2022 оны А/68 дугаар захирамж, 2022 оны 10 дугаар сарын 17-ний өдрийн "Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг өндөржүүлж, мэргэшсэн төрийн албыг төлөвшүүлэх" аяны удирдамжийг үндэслэл болгов.

Хоёр. Зорилго

Хүнс, хөдөө аж ахуйн газрын ажилтан албан хаагчдын Ёс зүй, сахилга хариуцлагыг өндөржүүлэх, хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, шинэлэг шинэ санаачлаг туршлагыг түгээн дэлгэрүүлэх, асуудал тэдгээрийг шийдвэрлэх арга зам, цаашдын чиг хандлагыг тодорхойлох хэлэлцүүлгийн үр дүнгээр гарсан бүтээлч шийдэл арга хэмжээг дэмжихэд оршино.

Гурав. Хамрах хүрээ

- Хүнс, хөдөө аж ахуйн газрын алба, мэргэжилтэн, албан хаагчид

Дөрөв. Хугацаа

- 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 14 цагт

Тав. Зохион байгуулалт

Хүнс, хөдөө аж ахуйн газрын ажилтан албан хаагчдын Ёс зүй, сахилга хариуцлагын талаарх мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох тулгамдаж буй асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

Алба, нэгжүүд өгөгдсөн сэдвийн хүрээнд судалгаа шинжилгээ хийж илтгэл боловсруулан 2022 оны 11 дүгээр сарын 01-07-ны өдрийн 11 цаг хүртэл хугацаанд байгууллагын Ёс зүйн зөвлөлд ирүүлнэ.

Сэдэв:

- Захиргаа аж ахуйн алба – Төрийн албан хаагчийн Ёс зүй, сахилга хариуцлагын талаарх хууль эрх зүйн орчин, Төрөөс баримталж буй бодлого
- Үйлдвэр худалдаа үйлчилгээний алба – Төрийн албан хаагчийн сахилга хариуцлага, төрийн албаны нэр хүнд
- Мал үржлийн алба – Төрийн албан хаагчийн манлайлал, Ёс зүйн харилцаа хандлага

Зургаа. Хэлэлцүүлгийн үр дүн

Хэлэлцүүлгийн үр дүн, гарсан санал, шийдвэрийг Ёс зүйн зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг ханган ажиллана.

Хэлэлцүүлгийн хөтөлбөр

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
1	Хэлэлцүүлгийн нээлт	14:00	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
2	Хэлэлцүүлгийн удирдамж, хөтөлбөрийг танилцуулах	14:04-14:10	Ёс зүйн зөвлөл
3	Төрийн албан хаагчийн Ёс зүй, сахилга хариуцлагын талаарх хууль эрх зүйн орчин, Төрөөс баримталж буй бодлого	14:10-14:30	Захиргаа аж ахуйн албаны дарга
4	Төрийн албан хаагчийн сахилга хариуцлага, төрийн албаны нэр хүнд	14:30-14:50	Үйлдвэр худалдаа, үйлчилгээний албаны дарга
5	Төрийн албан хаагчийн манлайлал, Ёс зүйн харилцаа хандлага	14:50-15:10	Мал үржлийн албаны дарга
6	Асуулт хариулт санал авах	15:10-16:00	Хэлэлцүүлэгт оролцогчид
7	Хэлэлцүүлгийн хаалт, үнэлэлт дүгнэлт	16:00-16:10	Ёс зүйн зөвлөл